



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/63

Чойр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагаас манай аймгийн малчин өрхүүд болон хүүхэд рүү чиглэсэн хүмүүнлэгийн “Дулаан өвөлжье” аяны хүрээнд 60,000,000 (жаран сая) төгрөгийн туслалцаа үзүүлэн ажиллаж байгаа тул тус аянд нэгдэхийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалж, чиглэл болгон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Т.Баясгалан)-д үүрэг болгосугай.

2. “Дулаан өвөлжье” аянд нэгдэж 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дэмжлэгт шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ ДАРГА



Б.НАРАНБААТАР

4210400154